



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/55

Өмнөдэлгэр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8.5 дахь хэсгийг заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд малчдад төр засгийн бодлого шийдвэрийг сурталчлах, мэдээ мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах зорилгоор “Малчдын зөвлөгөөн-2026”-ыг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсугай.

2.Зөвлөгөөн зохион байгуулахад шаардагдах төсвийг Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын санхүүжилтээс зарцуулахыг нягтлан бодогч (Ц.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.



Р.ЭНХТӨР